



## МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2021 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А-280

Улаанбаатар хот

Төв банкнаас банканд зээл, санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгө болон худалдан авах үнэт цаасны жагсаалтыг батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15 дугаар зүйл, 20<sup>1</sup> дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалт, Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг Төрөөс нэг удаа төлөх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх заалт, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.3 дахь хэсэг, УИХ-ын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай 21 дүгээр тогтоол, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хурлын 6 дугаар тогтоолын 4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төв банкнаас банканд зээл, санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгө болон худалдан авах үнэт цаасны жагсаалтыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.


2.Төв банкнаас банканд зээл, санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгө болон худалдан авах үнэт цаасны жагсаалтыг шинэчлэх тухай саналыг тодорхой нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагыг харгалзан тухай бүр боловсруулж, танилцуулахыг Эрсдэлийн удирдлагын алба (Д.Баянзул)-нд даалгасугай.

3.Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар (А.Энхжин), Эрсдэлийн удирдлагын алба (Д.Баянзул), Санхүү бүртгэлийн газар (Ц.Гарьд)-т тус тус үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны А-98 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

5.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Т.Амарсайхан)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



БЛХАГВАСҮРЭН

14 1569



ТӨВ БАНКНААС БАНКАНД ЗЭЭЛ, САНХҮҮЖИЛТ ОЛГОХОД БАРЬЦААЛАХ  
ХӨРӨНГӨ БОЛОН РЕПО НӨХЦӨЛӨӨР ХУДАЛДАН АВАХ ҮНЭТ ЦААСНЫ  
ЖАГСААЛТ

1. Төв банкнаас зээл, санхүүжилт олгоход дараах төрлийн активыг барьцаа хөрөнгөд авна. Үүнд:

Зээл, санхүүжилтийн төрөл	Барьцаа хөрөнгө <sup>1</sup>
<b>1. Нээлттэй захын үйл ажиллагаа</b>	
1.1 Репо арилжаа	Төв банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас, Эрдэнэс Монгол ХХК-иас гаргасан Хөгжлийн банкны баталгаатай Эрдэнэс бонд, МИК Актив ТЗК ХХК-иас гаргасан ипотекийн зээлээр баталгаажсан бонд, Үнэт цаас санхүүжилтийн корпораци ХХК-ийн байгуулсан ТЗК-иас гаргасан давуу эрхтэй хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаас
<b>2. Санхүүжилтийн байнгын хэрэгсэл</b>	
2.1 Репо санхүүжилт	Төв банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас, Эрдэнэс Монгол ХХК-иас гаргасан Хөгжлийн банкны баталгаатай Эрдэнэс бонд, МИК Актив ТЗК ХХК-иас гаргасан ипотекийн зээлээр баталгаажсан бонд
2.2 Өдрийн репо хэлцэл	Төв банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас
<b>3. Барьцаат зээл</b>	Төв банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас, Монгол улсын Хөгжлийн банкны үнэт цаас, Хөгжлийн банкны баталгаатай Эрдэнэс Монгол ХХК-иас гаргасан Эрдэнэс бонд, МИК Актив ТЗК ХХК-иас гаргасан ипотекийн зээлээр баталгаажсан бонд, банкны хэвийн зээл

<sup>1</sup> Барьцаанд авах аливаа төрлийн үнэт цаас нь ҮЦТХТ ХХК-д бүртгэлтэй, биет бус үнэт цаас байна.



2. Төв банкны барьцаа хөрөнгийн эрсдэлийн хямдруулалтын хэмжээ, хувиар<sup>2</sup>

2.1 Тогтмол купонтой үнэт цаасны эрсдэлийн хямдруулалт:

Барьцаа хөрөнгө	Эрсдэлийн хямдруулалт (Барьцаа хөрөнгийн үлдэгдэл хугацаа)					
	0-1 жил	1-3 жил	3-5 жил	5-7 жил	7-10 жил	10+ жил
Засгийн газрын үнэт цаас	0.5	1.0	1.5	2.0	3.0	5.0
Хөгжлийн банкны үнэт цаас	1.0	1.5	2.5	3.5	4.5	8.0
Давуу эрхтэй ИЗББ <sup>3</sup>	20					
Энгийн эрхтэй ИЗББ <sup>4</sup>	40					
Давуу эрхтэй хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаас <sup>5</sup>	20					

2.2 Купонгүй үнэт цаасны эрсдэлийн хямдруулалт:

Барьцаа хөрөнгө	Эрсдэлийн хямдруулалт (Барьцаа хөрөнгийн үлдэгдэл хугацаа)					
	0-1 жил	1-3 жил	3-5 жил	5-7 жил	7-10 жил	10+ жил
Төв банкны үнэт цаас	0.5	2.0	2.5	3.0	4.0	7.0
Засгийн газрын үнэт цаас	0.5	2.0	2.5	3.0	4.0	7.0
Хөгжлийн банкны үнэт цаас	1.0	2.5	3.5	4.5	6.5	10.5
Эрдэнэс бонд <sup>6</sup>	40					

2.3 Банкны хэвийн зээлийн эрсдэлийн хямдруулалт:

Зээлийн үлдэгдэл хугацаа	Эрсдэлийн хямдруулалт
3 жил хүртэл	30
3 жилээс дээш	50

<sup>2</sup> -Төв банкнаас олгох санхүүжилтийн хэмжээг дараах томъёогоор тооцож, зуутын орон хүртэл бүхэлчилнэ.

$$F = C * \frac{100 - H}{100}$$

- F – Санхүүжилтийн хэмжээ
- C – Барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ
- H – Эрсдэлийн хямдруулалтын хэмжээ

<sup>3</sup> МИК Актив ТЗК ХХК-иас гаргасан ипотекийн зээлээр баталгаажсан бонд

<sup>4</sup> МИК Актив ТЗК ХХК-иас гаргасан ипотекийн зээлээр баталгаажсан бонд

<sup>5</sup> Үнэт цаас санхүүжилтийн корпораци ХХК-ийн байгуулсан ТЗК-иас гаргасан хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаас

<sup>6</sup> Эрдэнэс Монгол ХХК-иас гаргасан Хөгжлийн банкны баталгаатай Эрдэнэс бонд